

Орон бүхний пролетариат нар нэгдэгтүн! АНХ ДУГААР ТАВАН ЖИЛ

Төв аймгийн Намын Хороо, А.Д.Х-ын гүйцэтгэх захиргааны сонин

27 дахь жилдээ № 34 (2298) 1974 оны 5 дугаар сарын 1 ЛХАГВА

ЭВ НЭГДЛИЙН ИХ БАЯР

Өнөөдөр дэлхийн хөдөлмөрчдийн эв санааны нэгдлийн их баярын өдөр өө!

Майн баяр нь империалист түрэмгийлэл, колончлолын эсрэг эрх чөлөө, ардчилал, тусгаар тогтнолын төлөө тэмцэгч улс түмний эв санааны нэгдлийн баяр мөн.

Олон улсын коммунист ажилчны хөдөлгөөний өв санд ажилчин ангийн тэмцлийн арга, хэлбэр нийгмийг хувьсгалд ёсоор өөрчлөн шинэтгэхэд үлэмжийн их хувь нэмэр оруулсан Октябрийн социалист их хувьсгал нь Оросын пролетариат нарын төдийгүй бүх дэлхийн коммунист хөдөлгөөний түүхэнд том ялалт болсон юм. Октябриар эх авч бүрэлдэн тогтсон дэлхийн социалист систем нь нийгмийн хөгжлийн бодит хуудлуудын үйлчилгээ, төлөвлөгөөт хөгжлийн давуу талд тулгуурлан түргэн хурдацтай хөгжиж, түүхэн богино хугацаанд нийгмийн хөгжлийн шийдвэрлэх хүчин зүйл боллоо.

Дэлхийн социалист системийн давуу чанар юуны өмнө аж ахуйн ололт амжилтаар харагдаж байна. Манай ертөнцийн хүн амын 32,9 хувь, газар нутгийн 26 хувийг өвлөж байгаа социалист системийн орнууд дэлхийн нийт бүтээгдэхүүний 40 хувийг үйлдвэрлэж байна.

Эдийн засгийн харилцан туслах зөвлөлийн гишүүн орнууд 1950 онд дэлхийн аж үйлдвэрийн бүтээгдэхүүний 18 хувийг үйлдвэрлэж байсан бол одоо 33 хувийг үйлдвэрлэх боллоо.

Орчин үед үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн империализмын колоничлол, шинэ колоничлолын эсрэг үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнол, нийгмийн дэвшил хөгжлийн төлөө тэмцэлдээ асар их амжилт олж байна.

Коммунист хөдөлгөөний интернационал хамтын ажиллагаа ихээхэн өсч байгааг олон улсын коммунист ажилчны намуудын 1957, 1960, 1969 оны Москвагийн зөвлөлтөөн

яруу тод харууллаа.

Олон улсын коммунист хөдөлгөөний салшгүй бүрэлдэхүүн хэсэг МАХН эдгээр зөвлөлтөөнөөс баталсан жанжин шугамыг тууштай баримтлан хэрэгжүүлэхийн төлөө үлэмжийн хүч чармайлт тавьж зохих хувь оруулж байна. Манай орны хөдөлмөрчид дэлхийн ажилчин анги, дарлагдсан ард түмнээс нийгмийн болон үндэсний дарлалыг устгахын төлөө жинхэнэ эрх чөлөө, жаргалант амьдралын төлөө хийх тэмцлийг дэмжиж эв санааныхаа нэгдлийг илэрхийлж байна. Социалист капиталист хоёр системийн үзэл суртлын ширүүн тэмцлийн өнөөгийн нөхцөлд манай намаас хөдөлмөрчид түүний дотор залуу үеийг ажилчин ангийн эв санааны нэгдлийн үзлээр хүмүүжүүлэх их ажлыг явуулж байна.

Манай орны хөдөлмөрчид майн их баярыг бүтээлч хөдөлмөрийн арвин дээжээр утгалаг сайхан заншилтай билээ.

Улс ардын аж ахуй, соёлыг хөгжүүлэх V таван жилийн төлөвлөгөөг биелүүлэх найдвартай үндсийг бүрэлдүүлэгч—1974 оны төлөвлөгөөт зорилтыг хугацааны нь өмнө биелүүлж МАХН-ын III их хурал, БНМАУ-ыг тунхагласны 50 жилийн ойд ажлын өндөр амжилтаар бэлэг барихаар манай аймгийн хөдөлмөрчид, бүх ард түмний социалист уралдааныг эрчимтэй өрнүүлэн ажиллаж байна.

Манай аймгийн хөдөлмөрчид малчид баатарлааар хөдөлмөрлөн өнгөрсөн оны мөн үстэй харьцуулахад гарсан төлөө 26,3 хувиар илүү бойжуулж, малын зүй бусын хорогдлыг 42,2 хувиар багасгаж үйлдвэр, худалдаа, тээвэр, холбооны байгууллагууд 1 улирлын төлөвлөгөөг 100, —138,7, а й м г и й н хэмжээний нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэх төлөвлөгөөг 111,9 хувиар биелүүлсэн хөдөлмөрийн арвин бүтээлээр дэлхийн хөдөлмөрчдийн эв санааны нэгдлийн өдөр майн баяртайгаа золгов.

Майн баярт барьсан бэлэг

Аймгийн төвийн үйлдвэр аж ахуйн газрууд майн нэгний баярыг угтсан социалист уралдаан өрнүүлэн ажиллаж төлөвлөгөөт зорилтуудаа амжилттай биелүүлэв.

Аймгийн барилга угсралтын контор 4 дүгээр сарын төлөвлөгөөг 100,3 хувиар биелүүлсний дотор аймгийн 5 удаагийн а в а р г а барилгачин Д.Намерай даргатай эцсийн бүтээгдэхүүний нэгдүгээр, С.Сосорбурам даргатай нэгдсэн хоёрдугаар, Я.Жалбаа даргатай гуравдугаар бригадууд 4 дүгээр сарын төлөвлөгөөг 102,2—125,5 хувиар, барилгачин С.Наранхүү, Б.Баасанжав, Ц.Бадарч, Д.Галаа, З.Жамъяншарав нар төлөвлөгөөг 102,2—149,6 хувиар биелүүлж бусдыгаа хошуучлав.

Аймгийн Холбооны газар 4 дүгээр сарын холбооны орлого, харилцаа солилцолт, холбоо хөгжүүлэх төлөвлөгөөг 100—140,2 хувиар биелүүлэв.

Аймгийн Холбооны телефон, шуудан, цахилгаан, радио тасаг, Баянзүрх, Баянцогт, Өндөрширээт зэрэг 20 гаруй сумын холбооны салбар улирлын төлөвлөгөөг 102,6—148,8 хувиар биелүүлэв.

МАНАЙ СУРВАЛЖЛАГЧ

Таван жилийн төлөвлөгөөний тэргүүн эгнээнд хошуучлагчдад баяр хүргэе!



ЗУРАГ ДЭЭР: (Зүүн тараа) Баянцогтын холбооны салбарын эрхлэгч Ц.Гомбо, НААУ-ийн газрын төмөрчин Н.Банзаргач, Зам-ангийн мужаан Д.Содном нар V таван жилийн төлөвлөгөөг 2 жилийн өмнө 100,1—100,7 хувиар биелүүлж хамт олшоо хошуучилж явна.

Л.ДАМДИНДОРЖ-ийн авсан гэрэл зураг



БАЯРЫН ЦАХИЛГААН

Төв аймгийн Намын хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга нөхөр Ц.АДЪЯА, АДХ-ын гүйцэтгэх захиргааны дарга нөхөр Ц.ЖАМСРАН нарт

Майн нэгний баярыг тохиолдуулан Төв аймгийн хөдөлмөрчид болон та бүхэнд коммунист ёсны халуун баяр хүргэж хөдөлмөрийн амжилт, сайн сайхныг ерөөе.

ЗХУКН-ын Төв Хорооны Курган мужийн Намын хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга Ф.КНЯЗОВ, Курган мужийн Хөдөлмөрчдийн депутатуудын хурлын гүйцэтгэх хорооны дарга А.МАХНЕВ

Монгол—Зөвлөлтийн найрамдлын нийгэмлэгийн Төв аймгийн зөвлөлийн дарга нөхөр Х.БИЛГЭЭД

Бүх дэлхийн хөдөлмөрчдийн хаврын баярыг тохиолдуулж Төв аймгийн хөдөлмөрчид болон танд баяр хүргэж БНМАУ-ыг тунхагласны их ойн жилд эдийн засаг, соёлын хөгжилт болон хөдөлмөрчдийн сайн сайхан аж амьдралын төлөө шинэ шинэ их амжилт олохыг ерөөе.

Зөвлөлт—Монголын найрамдлын нийгэмлэгийн Курган мужийн салбарын дарга П. А. МАТБЕЕВ

ТАРИАЛАЛТ ЭХЭЛЛЭЭ

Тус аймгийн САА, ТАА, ХАА-н нэгдэл улсын тэргүүний тариаланчдын зөвлөлгөөний шийдвэрийг хэрэгжүүлэн МАХН-ын III их хурал болон БНМАУ-ын тунхагласны 50 жилийн ой угтсан социалист уралдаан өрнүүлж энэ жил зуу гаруй мянган га газар үр тариа тариалах ажилдаа бэлтгэл зохион байгуулалт сайтай орлоо.

Аймгийн хэмжээгээр өнөө жилийн тариалалтанд дугуйт болон гинжит трактор 350, үрлэгч 798, бул 1000, бусад чиргүүл, дүүжин машин механизм 345 аяргат болон гарч өдөрт 8500—9800 га газар үр суулгаж байна.

Тарианы 24000 тонн үрэнд I, II, III цэвэрлэгээ хийж ялгаж ариутган сайтар томчилж дугаарласан соёолот, цэвэршилт сайтай үрийг борлоотой хамт тариалж эхэллээ.

Хаврын хагатаанд эрт ороод амжилттай ажиллаж байгаа Жаргалант, Баянцогт, Угтаал, Борнуурын САА, Эрдэнэсантын

ТАА, Заамар сумын «Заамар», Лүн сумын «Энхтуул» нэгдлийн тариаланчдын үр суулгалт өнгөрсөн оны мөн үеэс ахцтай байна.


Дээрх сумд тариалалтыг богино хугацаанд чартай дуусгах график төлөвлөгөө гаргаж энэ ажлыг удирдах штаб байгуулан ажилд нь оруулжээ. Тракторчид болон үр суулгах техник дээр ажиллаж байгаа хүмүүсийн хөдөлмөр хамгаалалт анхаарч аюулгүйн техникийн дүрмийг төрөл бүрийн хэлбэрээр сурталчилж байгаагийн дотор тасаг, бригад техникч дээр тариалалтын бэлтгэлийг сайн хангуулан техникийг амжилттай засварлаж тариаланчдын 1—2 өдрийн семинар хийж хэн ямар үүрэг гүйцэтгэхийг ойлгуулсан үндсэн дээр социалист уралдаанд үүрэг авахуулан явцыг 3, 5, 7 хоног оор цуваагаар байр эзлүүлэн дүгнэж тэргүүний тасаг, бригад, салаанд туг дарцаг шил-

жүүлэн, техникчдийн өдрийн тэргүүн шалгаруулан шагнаж байна.

1974 оныг өндөр ургацын жил болгож өнгөрсөн жилээс дутуугүй ургац авах зорилт дэвшүүлэн бүх талбайн 70—80 хувийг тоонолжлон тариалах, га-д орох үрийн нормыг нэмж хөрсийг тарихын өмнө хойно зуун хувь булдаж байна.

Энэ ажилд өнгөрсөн жил ургац хураалтын улсын уралдаанд түрүүлж шагнал авсан Эрдэнэсантын ТАА-н тракторчин, намын гишүүн Д. Ухнаа, Н. Пүрэвжав, Баянцогтын САА-н тракторчин, Ардын Их Хурлын депутат Д. Очир, намын гишүүн Н. Будэнийн, Угтаалын САА-н тракторчин, БНМАУ-ын хөдөлмөрийн баатар Г. Алтанхүү, Жаргалантын САА-н тракторчин, БНМАУ-ын хөдөлмөрийн баатар М. Чойжамц ахлагчид талсаа үр суулгах 6 өдрийн ажлыг 4—5 өдөр хийж хөдөлмөр шатахуун хэмээн үлгэр жишээ ажиллаж байна.

Ш. ЦЭРЭНДОО



Мал эцгийнхээ туршлагаар ажиллаж буй 16 настай хүү Дэнзэнг нутгийнхан нь хашар сайн малчин болно гэжгэдэг. Угтаалын САА-н хоньчин Х. Намсрай, хүү Н. Дэнзэнийхээ хамтаар хургалуулах 800 гаруй хонь хариуцан маллаж одоо Уушиг гэдэг газар тухай сайн хаваржиж 762 хониноос 763 хурга эсэн мөнд бойжуулж байна.

ЗУРАГ ДЭЭР: Хоньчин хүү Н. Дэнзэн

Ш. ЦЭРЭНДОО-гийн авсан гэрэл зураг

МАЛ ТАРГАЛУУЛАХ ОТОРТ НИЙТЭЭР ГАРЦАГААЙ

Мал сүрэгт дээд зэргийн тарга хүч авахуулах нь мал сүргийн тогтвортой өсөлтийг хангаж, ихээхэн хэмжээний махны нөөцийг олох үндсэн нөхцөл мөн.

Өнгөрсөн оны мал оторлолтын үр дүнд аймгийн дүнгээр малын дундаж амьдны жин үнээ 86, бяруу 77, хонь 16,5, төлөг 15,4, ямаа 9,7, борлон 14,2 кг-аар тус тус нэмэгдэж нийт мал сүргийн 96,6 хувь нь дунд ба дундаас дээш тарга хүч авсаны гадна Баян-өнжүүл, Лүн, Баянцогт, Заамар, Алтанбулаг сумд отор нүүдэл өргөн айлсалтыг бусдаасаа илүү анхаарч сайн зохион байгуулжээ.

Энэ онд том малын зүй бус хоргодол урьд оны мөн үеийнхээс 42,2 хувь буюу 6,3 мянган, маллар, телийн хоргодол 2,2 мянгаар бага байна.

Энэ нь тарган мал тал бүрийн ашигтайг нотолж

зун, намар отроор мал сүрэгтээ тарга хүч сайн авахуулсны үр дүн юм.

Мал сүрэгтээ отор бэлчээрээр тарга хүч авахуулах энэ жилийн ажил эхлэх боллоо.

Үүнтэй холбогдуулж саяхан мал таргалуулалт оторлолтын ажлын 1973 оны дүн цаашдын зорилтын тухай хэлэлцсэн зооэдийн засгийн бага хурлаас мал таргалуулах оторын талаар онол практикийн санал дүгнэлтүүд гаргалаа.

Үүнээс үзэхэд мал таргалуулалтыг үндсэнд нь элгэн, махан, өөхөн, холимог, чөмгөн тарга гэж хуваадаг юм. Зуны бэлчээрийн ургамлын химийн бүрэлдэхүүн нь малын организмд зайшгүй шаардлагатай бүх төрлийн мак-о микро элементүүд витаминнаар баялгийн дээр усны хэмжээ 70 хувь хүртэл байдгаас малын элгэнд шимт бодис хуримт-

лагдаж биеийн эд эсийн завсардах шингэний хэмжээг нэмэгдүүлж холбогч эдийг сийрэгжүүлж багтаамжийг ихэсгэж өгдөг байна.

Энэ үеийг элгэн буюу усан таргын үе гэнэ.

Иймд элгэн буюу усан таргын малд авахуулахын тулд эр сувай малыг агь нүдэлсэн нөмөр нөөлөг, ногоо эрт цухуйсан газраар (5 сарын 1—нээс 6 сарын дунд үе хүртэл) оторлох нь чухал.

Мөн 7 сарын сүүлээс 8 дугаар сарын эхээр ургамлын доторхи усны хэмжээ ажмаар багасах хуурай бодис ихээхэн хуримтлагдан малын биеийн хуурай бодисын хэмжээ ихсэж эд эсийн завсарын шингэнийг түрж улмаар уураг нүүрс усны хуримтлалыг бий болгон махлах процесс явагдаж хар махаар дүүрч ирэхийг махан таргын үе гэх бөгөөд энэ

КУРГАН НУТГИЙН СОНИНООС

ЗСБНХОУ-ын Лениний одонт Курган мужийн Намын хорооны урилгаар аймгийн Намын хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга Ц. Адъяа тэргүүтэй төлөөлөгчид бид 4 дүгээр сарын 8-наас 13-ныг дуустал Курган мужид зочлов.

Бид Иркутскээс нисээд Кургантай залгаа орших Челябинскт буув.

Тэнд биднийг Челябинск мужийн Намын хорооны нарийн бичгийн дарга Н. П. Лаврентьев, хүн эмнэлгийн институтын доцент Т. И. Переконская бусад хүмүүсийн хамт угтан авч Курган мужийн хил хүртэл үдэж өгөв.

Бид Шуганскийн районоор дайрч 4 дүгээр сарын 8-ны орой Курган мужийн төвд хүрэлцэн очив.

Курган мужийн албан байгууллага болон хотын гудамж талбайнуудад орос монгол хэлээр «Монгол нөхөддөө баяр хүргэе»,

«Манай оронд тавтай зочлоорой», «Зөвлөлт-Монголын ард түмэн ахан дүүс», «Зөвлөлт-Монголын мөнхийн найрамдал мандтугай» гэсэн лозун, хоёр улсын далбаа, Д. Сүхбаатар, Л. И. Брежнев, Ю. Цэдэнбал нарын хөрөг зургийг тавьж чимэглэсэн байв.

Мөн соёлын ордон, клуб, номын сан, сургууль, үйлдвэрийн газруудад Д. Сүхбаатар, Ю. Цэдэнбал нарын том хөргийг тавьж Зөвлөлт-Монголын далбаа сүртэй намирч байв.

Явсан газар бүрт гудамж талбай, үйлдвэрлэлийн байранд хүмүүс Монгол-Зөвлөлтийн далбаа, барьж жагсан «Централын аймга», «Найрамдал-дружба» гэж орос монголоор баяр хүргэж байв.

—Сургууль, үйлдвэр, албан газруудад найрамдлын цуглаан өргөн зохиож байсан төдийгүй, зарим гудамж талбай, үйлдвэрийн газрын орчимд хөдөлмөрчид өөрсдөө цугларан бидэнтэй уулзаж манай орны болон тус аймгийн тухай мэдэхийг хүссэнээ илэрхийлж байсан юм.

Манай төлөөлөгчдийг Курган мужийн Намын хороо, ХД-ын гүйцэтгэх хороо, УЭ-ийн зөвлөл хүлээн авч өөрсдийн ажлын талаар харилцан мэдэл хийв. Бид Лениндурсгалын хөшөө, эх орны дайнд амь үрэгдэгсдийн дурсгалд зориулсан Мөнх алдрын түүдэгт цэцэг өргөв.

Курган хотын байдалтай танилцлаа. Курган хот нь Тобольскын эрэг дагуу уртаараа 16 км, өргөнөөрөө 4—5 км бөгөөд 280 мянга гаруй хүнтэй үзэсгэлэнт сайхан хот юм.

Хотын байдалтай танилцах үед эмийн үйлдвэр, тэндэхийн ажилчдын биеийн тамирын ордон, 36, 48 дугаар дунд сургуулиудаар орж, 48 дугаар сургууль дээр найрамдлын цуглаан болж биднийг хүндэт пионер тэсүүлэв.

Химийн машин үйлдвэрийн ажилчдын соёлын ордон, үйлдвэрчний эвлэлийн зөвлөлийн биеийн тамирын ордон, хотын номын сан, музей, хуримын ордон, онгоцны буудал, ХАА-н машины үйлдвэр, сүүний завод, гэмтэл согогийг судлан эмчлэх, хүн эмнэлгийн эрдэм шинжилгээний туршлагын институт, хотын зарим нэгдсэн эмнэлгүүдээр оров.

Ургалжлал бий

нь 8 дугаар сар хүртэл үргэлжилнэ.

Дараа нь өөхөн тарга авах ёстой.

Өөхөн тарга нь ургамлын буурцаг боловсрох үеэс эхлэн 10 дугаар сарын дунд үе хүртэл явагдана.

Энэ үед мал бүрт тохирсон бэлчээрийг сонгон нутаглаж өдөрт 2—оос доошгүй удаа усалж байх шаардлагатай.

Отор нүүдэл хийсэн урьд оны байдлаас үзэхэд бэлтгэлийн насны малыг шахаж бордохгүй, том малыг оторлоход голлохихоод төл малын тарга хүчинд муу анхаарч, отор хийх нутгийг зөв сонгохгүй, оторчдыг эргэж тойрох, үйлчлэх явдал хангалтгүй, өргөн айлсалт, бодын сүү ашиглах ажлаас хэтрэхгүй байсан нийтлэг дутагдлыг энэ жил давтаж болохгүй.

Юуны урьд оторт гарах малд жигнэлт хийж, оторчдод тарга хүчний даалгарыг өгөх хэрэгтэй. Төл малд отор бэлчээр

рээр тарга хүч авахуулах ажлыг сайн зохион байгуулахад онцгой анхаарвал зохино.

Оторчид хоол хүнс, ачлага уналга, орон байр зэрэг хувийн бэлтгэлээ сайтар базаахын зэрэгцээ сум, орон нутгийн нам, захиргаа, олон нийтийн байгууллагаас оторчдын дунд зохиох ажлыг нарийн төлөвлөж, оторт гарснаас хойш яаруу сандруу үйлчилсэн, эргэж тойрсон болдог буруу зуршилг арилгавал зохино.

Отрын малчдыг худалдаа, соёлын үйлчилгээгээр байнга хангах явдал чухал байна.

Өргөн айлсалтаар буусан малчдын ар гэрийнхнийг сүү сааль ашиглах төдийгүй гэр орноо будаж янзлах, хувац оёх, мал ноослох, хадлан тэжээл бэлтгэх ажилд оролцуулж өргөн айлсалтыг жинхэнэ үйлдвэрлэл, соёл хүмүүжлийн төв болгох зорилт тавигдаж байна.

Л. ГУНГААВУУ

Уралдаант аймгийнхны туршлагаас

Уралдаант ажилд уурайлан урамтай зоригтой олон Өвөрхангай аймгийн... Өвдөрөг үйлтэй түмэнтэй учран золгосон тухай өчүүхэн тэмдэглэлээ, Ц. Гайтав найрагчийн шилийг дарж, ган үзгийн гарцыг сорьсон залуу зохиолч С. Шаамангийн энэ бадгаар эхлэхээр шуудсан минь энэ билээ.

Орион, олон нуурын хоньчин

Насан өндөр, үсэн буурал авч нэгдэл нийгмээ хөгжүүлэх чин санаа тавин ажиллаж, далан насныхаа жаргалыг эдэлж яваа хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон энгэртэй гялалзуулсан хоньчин Ц. Цэдэвсүрэнтийг уулзахад;

—Өвгөм ах нь насаараа мал дагасан хүн. Манай суурь хүний гар хардаггүй. Хашаа барих засварлах, өвс тэжээл бэлтгэх, хужир шүү татах, төл бойжуулах ажлыг суурийнхаа хүчээр л хийдэг.

Хээл хамгаалж чадвал төл сайн бойжуулж болно. Манайх сүүлийн жилүүдэд төлөө бүрэн бойжуулж ирсэн гэж Бүрд сумын хошой аварга ярих.

Эднийх сүү орлох тэжээл бэлтгэхдээ сүүгээ хөөрүүлэнгүүт шар будаа хийж хончуулаад маргааш нь шүүж аваад сүүдэр газарт хатааж нүдэж нунтаглан усанд найруулж самраад шар тос бага зэрэг хийж эх мал төл тэжээдэг ажээ.

Мөн өвөлжөөндөө хужир тарьж мал сүргээ эрдэс тэжээлээр хангадаг юм байна.

Зүйлээр зүйл бүрийн сонинтой

Зүйл сумын «Хөгжил» нэгдлээр ороход хүн ард нь нэгдлээ хөгжүүлж, ма-

лаа өсгөнө гэж урам зоригтой ярьцагааж байлаа. Бидний хуучин танил нөхөр Лодой Намын дээд сургууль төгсгөж энд нэгдлийн даргаар томилогдон ирээд удаагүй ч гэсэн их зүйл бодож боловсруулан, тодорхой зорилт дэвшүүлжээ.

Бүх ард түмний социалист уралдааны жил 1974 онд мал сүргээ 8,8 мянгаар өсгөх, өргөн айлсалтыг зохион байгуулж мал таргалуулах ажилд дэвшилт хийх, МАА-н материаллаг баазыг бэхжүүлэх, өвөлжөөн дээр өвбөөс тарих, өвсийг даршлах ажлыг суурьт нэвтрүүлэх зэ-

—Дансанд мөнх мал гэнэ ээр?

—Тиймээ гээд нэгдлийн дарга, хоньчин Пэрэнлэй-жанцагийн өлгөөстэй байсан гэрчилгээг үзүүлэв. Ихэр сүрэгтийн гэрчилгээ, 5 төгрөгийн шагналттай ажээ. Ихэр төл бүрт уг гэрчилгээ, мөнгөн шагнал олгодог байна.

Энэ гэрчилгээг нэгдлийн дарга, мал аж ахуйн мэргэжилтнүүд бригадын дарга нар газар дээр нь олгож, ихэр хурга, ишгийг имнэж, орлогод авдаг ажээ. Энэ нь малчдын идэвхийг дээшлүүлж, ихэр төлийг бүрэн бойжуулахад түлхэц өгч байна.

ТҮРҮҮ МАГНАЙ АЛДАХГҮЙН ТӨЛӨӨ

(ТЭМДЭГЛЭЛ)

рэг олон зүйлийг хийхээр шийдвэрлэж, зарим нь хэрэгжиж эхэлж байна.

Хоньчин Д. Түмэн-баярынх өвсийн дарш хийж, зун намрын ааг ханхалсан ногоон өвсөөр төлөөсөн мал, гарсан төлөө тэжээж байлаа.

Эднийх 300 литрийн багтаамжтай торхыг нүх ухаж суулгаад дороос нь хөрхөнгөөр галлаж доторхи усыг нь байнга долзтгэж, хонио усалж байгаа нь ансаархан бөгөөд суурь бүрт нэвтрүүлүүштэй гар усалгааны цэг болсон байв.

Энэ хоньчин хаваржааныхаа дэргэд хужрын долооц санаачлан хийж маалаа эрдэс тэжээлээр хангах нөхцөлийг бүрдүүлжээ. Иймээс ч төл сайн бойжиж, мал нь жилбэ сайтай төлөж байв.

—Дансанд мөнх мал гэж нэгдлийн даргын хэлсэн үг анхаарал татав.

Хээл авсан үнээ бүрийг малчдад актаар хүлээлгэн өгч, 3 төгрөгийн шагналыг олгодог нь гарсан төлийг бүрэн бойжуулахад тэдний хариуцлагыг өндөржүүлж байгаа ач холбогдолтой юм.

Эмнэг хангалын эзэн 14 настай охин Д. Мягмарыг 20 дахь тэмцээг сургаж байхад нь тааралдав. Тэдний гадаа гурван тэмээ уяатай байв.

Тэмээ сургах талаараа нэрд гарсан бөгөөд хашир малчид шинг дадлагажсан энэ охин жил бүр олон тэмээг уналга эдэлгээнд сургаж эмнэг хангалын жинхэнэ эзэн нь болжээ.

Зүйл сумын хувьд ийнхүү зүйл зүйлийн сонин элбэгтэй байлаа.

Оч нэгдлийн «оч» нь: Өлзийт сумын «Оч» нэгдлийн 1 дүгээр бригадын хоньчин Д. Намсрайжавын ажилсаг малчин болохыг

хүн бүр магтан, манай нэгдлийн «Оч» нь гэлцэж байв.

Хашаа байраа салхи сийгэхгүйгээр дулаалж, хэвтрийг хөх буушаар зузаалж, төлийг хөрвийн үе шатаар бойжуулах бэлтгэлийг үнэхээр сайн хийжээ.

Урт нарийн модыг өвсөөр ороож, резинээр чангалж татаад таазнаас дүүжилжээ.

Тусгай онгоцонд ус, хужир, бас сараалжинд нарийн өвс хийж тавьжээ.

Эх төл хоёр өвс тэжээл, хужир шүү, усаар бүрэн хангагдсан учир төлөөсөн мал жилбэ сайтай, гарсан төл нь хурдан торниж, эрүүл чийрэг бойжиж байв.

Д. Намсрайжав ахлагч-

чиж тослох болон гадуур хувцасны шороо тоос цэвэрлэх, авто үзэгт шаардлагатай өнгийн бэх хийж өгөх зэрэг 50 гаруй нэртэй үйлчилгээ хийж байлаа.

НААҮГ, ахуй үйлчилгээний комбинатаар явахад жолоочоосоо эхлээд хос мэргэжилтэй 5 хүний бүрэлдэхүүнтэй тусгай орон сууц бүхий нүүдлийн үйлчилгээний хэсэг 63,5 мянган километр нутгаар хөндлөн гулд довтолгон явж жилийн аль ч улиралд малчин олны «анзархайг хатгаж» явдаг нь анхаарал татаж байлаа. Тэд үүний зэрэгцээ химийн цэвэрлэгээнд өгөх зүйлийн захиалгыг хүлээн авч, цэвэрлэсэн зүйлээ тарааж явдаг бас нэг ажлыг давхар амжуулдаг юм байна.

Нарийн хурган долроос эхлээд «азарган нэхий» дээл хуртэл цэвэрлэж тавьсан нь сээлзүүр салхитай тэр нэгэн өдөр сэтгэлд үнэхээр өгг байж билээ.

Нийтийн орон сууцныг тэргүүний эзэмшигчдийг шалгаруулан төв байгууллагатаа тавьж шагналыг хүлээлгэсэн, халуун усанд орогчидол зориулан хувцас угаах тусгай тасалгаа бэлтгэж, түүндээ угаалгын төхөөрөмж (угаагч машин, индүү, саван нидрэг) тавьж ашиглуулдаг зэрэг санаа аммаар сайхан туршлага энд олон байлаа.

Арвайхээр хотын албан газруудаар явахад 1973 оны бүх ард түмний социалист уралдаанд аман хүүзүү булаалдсан дүнтэй байснаа аймгийн Холбооны газар, Хүнсний комбинат, Ардын боловсролын хэлтэс, НААҮГ-ын нөхөд зүй ёсоор бахдан өгүүлж байлаа.

А. ДАВАНЯМ
П. ЖАНЧИВ



Борнуурын САА-н хуучин ногооны 1,2 дугаар бригад өнөө жил тариалах байцаагаа үрслүүлэх ажлыг амжилттай хийж 9000 ам дөрвөлжин талбайд 5 сая үрслэг бойжуулж байна.

ЗУРАГ ДЭЭР: (Дээд талд) Ногоочид үрслэг бойжуулж байгаа нь;

(Доод талд) Тус САА-н тракторч Б. Балжинням хагалгааг агротехникийн шаардлагын дагуу богино хугацаанд хийхээр уралдаанд үүрэг авч ажиллаж өөрийн нормоо 120—130 хувь биелүүлж байна.

Ш. ЦЭРЭНДОО-гийн авсан гэрэл зураг

Сонирхолтой тэмцээний өрсөлдөөнт тоглолт

«Анхдугаар таван жил» сонин нэрэмжит волейболын аварга баг, тамирчдыг шалгаруулах тэмцээн ид дундаа үргэлжилж байна.

Танхим дүүрэн алга тшилт нийгнэж радио хоолойгоор нэвтрүүлэгч шүүгч;

—16 номерын тамирчин (Төвийн 10 жилийн дунд сургуулийн эрэгтэйчүүдийн багийн ахлагч Лхагвацэрэн) бөмбөгийг тоглолтонд оруулах гэж байна. Давуулалт амжилттай боллоо. 5 номерын тамирчин авлаа. (ЭХГ-ын тамирчин Болд) 3 номер өргөлөө (ЭХГ-ын тамирчин Алтангэрэл) 5 номер цохилоо. Шүглийн дуу тас хийв. Бөмбөг дотор унажээ. Нэвтрүүлэгч-шүүгчийн дуу үргэлжилж ахмад тамирчин Болд амжилттай довтолж бөмбөгийг өөрийн багт авч ирлээ. Тоо 13:13. Ийнхүү ЭХГ, төвийн 10 жилийн дунд сургуулийн эрэгтэйчүүдийн багийн тоглолт

онц идэвхтэй, тун сонирхолтой болов.

Уг тэмцээнд эрэгтэйчүүдийн 9 эмэгтэйчүүдийн 6 багийн 100 гаруй тамирчинд оролцжээ.

Төвийн 10 жилийн дунд сургууль, НААҮГ-ын эрэгтэйчүүдийн багийн 1,2 дугаар байр булаалдсан тоглолт эхэллээ. Волейболын спортын улсын II зэргийн тамирчин В. Төмөртогоо, залуу тамирчин Б. Доржоохүү, А. Дорждагва... нарын тоглолт үзэгчдийн талархал хүлээж байлаа.

НААҮГ, төвийн 10 жилийн дунд сургууль, ЭХГ-ын эрэгтэй, эмэгтэйчүүдийн баг 1,2,3 дугаар байр эзэлж, «Анхдугаар таван жил» сонин, «Ургац» нийгэмлэгийн диплом, сайшаалын үнэмлэх үнэ бүхий зүйлээр шагнагдав. Тэмцээнд амжилттай оролцсон Б. Доржоохүү, А. Дорждагва нарын зэрэг 10 шахам тамирчин спортын улсын II, III зэрэг биелүүлэв.

Б. ТОГООХҮҮ

САДАН ТӨРЛИЙН ЧИЛИ

«Талд миний садан нутагладаг юм»

ПАВЛО НЕРУДА

Санть-яго Номхон далайн эргээс
Сальвадор Альендегийн алтан нутгаас
Хүүхдийн дуу бахардан хадаж
Хүмүүсийн зүрхийг гаслангаар онов
Хунтууд энэ чинь юу гээч болж байна
Усан буудал үерт автсан юм шиг
Цусан мөрөн гудамжаар бялхаж
Гитлер гэнэт амилсан юм шиг
Гэгээн соёл түймэрт автаж
Хунтууд энд юу гээч болж байна
Ардын нэгдлийн засгийн газрын
Алаг туг намрч харагдсангүй
Тэнгэрийн гэрэлт од унтарсан шиг
Тэндэхийн гудамжаар Неруда алхсангүй
Хунтууд энд юу гээч болж байна
Тэмцэж олсон ардын жаргалыг
Гэгээн цагаан өдрөөр дээрэмдэж
Тив дэлхийг гэнэт цочирдуулсан
Гай гамшгийг Чилид хэн тарив аа
Хунтууд энд юу гээч болж байна
Кордлерийн салхийг агаараас таслах гэж
Корваланыг хорьж Альендег хороож
Хунтын шүүгчид зогсоо завгүй гэнэ
Хуягласан шорон багтах зайгүй гэнэ
Хунтууд энд юу гээч болж байна
Тунхаг алдраа багдаж өргөсөн Чили минь
Туулын усанд туяаран гэрэлтсэн Чили минь
Дөлтэй хувьсгалын гал болсон Чили минь
Дөнгө гянданд хэзээ ч хоригдохгүй Чили минь
Хунтууд энд юу гээч болж байна
Коммунист зүрхэнд ноцсон гал Чили минь
Коммунист тархинд сэтгэсэн ухаан Чили минь
Үнэнийг худлаас ялгаж чадна Чили минь
Үхлийг хүнээс зайлуулж чадна Чили минь
Хунтууд тэгээд юу ч болж чадахгүй
Аадрын үүл шиг ард түмэн нэгдэж
Аянгийн үерээр нутгаа угаахад
Эцсийн мөч нь ирж Пиночетууд
Эргүүлгэнд живж далдрах болно
Энхийн наранд Чили орон мандаа. Чили минь!

Ш. ЦЭРЭНДОО

ЭЗХТЗ байгуулагдсаны 25 жилийн ойд

АХ ДҮҮГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА

1949 онд байгуулагдсан ЭЗХТЗ нь Европ, Ази, Америк гурван тивийн есөн орныг хамарсан олон улсын нэр хүндтэй байгууллага болж эдгээр орнуудын эдийн засгийн тал бүрийн хамтын ажиллагаа улам өргөжин хөгжлийнхөө 25 жилийн дотор асар их амжилтанд хүрлээ.

ЭЗХТЗ нь гишүүн орнуудын хүч чармайлтыг нэгтгэн зохицуулж тэдний эдийн засгийг эрчимтэй хөгжүүлэхэд идэвхтэй нөлөө үзүүлж ирсэн бөгөөд социалист байгуулалтын цар хүрээ өргөжин социалист орнуудын хамтын ажиллагаа гүнзгийрэн хөгжих тутам түүний гүйцэтгэх үүрэг улам нэмэгдэж байна.

ЭЗХТЗ-ийн гишүүн орнууд 1950 онд дэлхийн аж үйлдвэрийн бүтээгдэхүүний 18 хувийг үйлдвэрлэж байсан бол одоо 33 хувийг үйлдвэрлэх боллоо. Энэ бол ЭЗХТЗ-ийн гишүүн орнуудын эдийн


Зураг дээр: Москва дахь Эдийн засгийн хариуцан туслал зөвлөлийн байшин. Түүнд тус зөвлөлийн нарийн бичгийн дарга нар байрладаг.

ТАСС-ын гэрэл зураг

доо хөгжлөөр ойртож, бие биенээсээ хамаарах болдог нь социалист эдийн засгийн интеграцийн чухал тал мөн.

ЭЗХТЗ-ийн гишүүн орнуудын хамтын ажиллагааг өргөжүүлэн гүнзгийрүүлж социалист эдийн засгийн интеграцийг хөгжүүлэх цогцолбор программыг 1971 онд тус зөвлөлийн XXV чуулгаанаар баталсан билээ.

Р. БАЯРСАЙХАН



Шинэ ном

Зуун мод хот дахь номын худалдаанд ойрын өдрүүдэд дор дурдсан шинэ номууд гарах болно. Үүнд: Зохиолч А. Дашнямын «Өлзийнарангийн өчил» дурсамж хэвлэгджээ. Уг туужид Манж-Хятадын ноёрхол гамин, бароны үймээн түйвээлтэнд нэрвэгдсэн ардууд эрх чөлөөний төлөө хувьсгалт тэмцэлд боссон эгэл жирийн ардуудын амьдрал эмцлийг Өлзийнаран хөв-

гүүнээр төлөөлүүлэн харуулжээ.

Зохиолч Т. Нямсүрэнгийн «Нутгийн бараа» гэдэг өгүүллэг туужуудын эмхтгэл, Ц. Ням-Осорын «Юу гэнээ хөө» гэдэг олон бүлэгт жүжгүүд, Ц. Цэдэнжавын «Өлгий дээр чинь» гэдэг шүлэг найраглалын түүвэр, Ж. Шагдарын «Найргийн дугараа» гэдэг шүлгийн түүвэр, Ази Африкийн зохиолчдын V бага хуралд зориулсан «Хоолой нийлүүлсэн дуулал»

гэдэг Ази Африкийн орны зохиолчдын бүтээлийн түүвэр, сургуулийн өмнөх насны хүүхдэд зориулан Л. Манлайбаатарын орчуулсан «Илбэдүүлсэн охин» гэдэг зурагт ном, ахлах ангийн сурагчдад зориулж Ц. Цэдэндамбаагийн найруулан бичсэн «Хомерийн туульс», Г. Ловорын орчуулж эмхтгэсэн «Газар газрын үлгэр» гэдэг түүвэр эмхтгэл зэрэг шинэ номууд худалдагдас тул хөдөлмөрчид өргөнөөр авч уншихаана уу!

С. ДЭМБЭРЭЛДОРЖ

ТАРИАН ТАЛБАЙД

Орчины газрыг доргиулж Ойртсоны чихийг дургиулж «ДТ-54» нүргэлнэ Дэргэд нь би эргэлдэнэ Тэртээ алсын энгэрээд Тэмдэгт газрын эхээд Хавийн газрыг доргиулсан Тавин дөрвөг өргүүлнэ Ажлы нь дүнг сонсох гэж Амт шимтий нь үзэх гэж Амьтан хүнд хэлэх гэж Ард нь би холхино

Б.ТОГООХҮҮ

Д.ТОВУУ



Ишиг маань хоорхонд оо
Ээжид нь би хохуулдаг дээ

С. ЦЭДЭВ-ийн авсан судалбар гэрэл зураг

Тавдугаар сарын цаг агаарын урьдчилсан мэдээ

Сарын дундаж агаарын температур 3-8 градус дулаан, хэвийн хэмжээнээс 2-3 градусаар хүйтэн, 2 дугаар 10 хоногт хүйтэвтэр шөнөдөө 3-8 градус хүйтэн, өдөртөө 4-9 градус дулаан, сар хуучийн эхээр дулаарч шөнөдөө 0-5 градус, өдөртөө 15-20 градус дулаан, бусад хугацаанд шөнөдөө 2 градус хүйтнээс 3 градус дулаан, өдөртөө 8-13 градус дулаан байна.

Орох хур тунадас 5-15 мм, зарим газраар 25-30 мм буюу хэвийн хэм-

жээнд, зарим газраар хэвийн хэмжээнээс их, нутгийн хойт хэсгээр хэвийн хэмжээнээс бага хур тунадастай. Сар шинийн дундуур 10-15-нд ба сарын хууч дундуур солигдмол үүлтэй, нойтон цас, сарын хууч дундуур бороо орно.

Бусад хугацаанд бага зэргийн үүлтэй, хур тунадас орохгүй. Салхи баруун хойноос секундэд 10-12 метр хүртэл ширүүсч зөөлөн шороон шуурга шуурна.

Энэ хавар тариалалтын үед тус орны төвийн нут-

таг, баруун зүгийн нутгийн зүүн хойт хэсэгт хөрсний хагалбарын (20 см) гүний чийг 20-40 мм буюу ургамлын цухуйлтанд хангалттай, зүүн өмнө зүгийн нутагт дунд зэрэг 8-14 мм бусад нутагт чийг хангалтгүй хөрсөнд чийг хангалттай байлаа ч дулаан дутагдан сарын сүүлчийг хүртэл ногоо ахицтай ургахгүй төлөвтэй байна.

Энэ 5 дугаар сард ихэнх нутагт хур тунадас бага, хавсрагатай байна.

Ус, цаг уурын товчоо